



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 2 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын Шадар сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

С.АМАРСАЙХАН



Засгийн газрын 2021 оны 45 дугаар
тогтоолын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын (цаашид “халдвар” гэх) тархалтын түвшинг тогтоож, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, халдварын тархалтын түвшинтэй уялдуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахдаа тухайн нөхцөлд тохируулан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарлах, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах зарчим баримтална.

1.3.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг тогтооходоо халдварын тархалтын түвшин, нийгэм, эдийн засгийн болон бусад нөхцөл байдалд үндэслэнэ.

1.4.“Халдварын тархалтын түвшин”-г энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.4-т заасан шалгуур үзүүлэлтийн үр дүнг үндэслэн тодорхойлно.

Хоёр.Халдварын тархалтын түвшин

2.1.Халдварын тархалт нь дараахь түвшинтэй байна:

2.1.1. “Ногоон түвшин” (халдвар илрээгүй):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 28 хоногийн хугацаанд шинээр халдвар бүртгэгдээгүй байх.

2.1.2. “Шар түвшин” (зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн болон зөөвөрлөгдөн ирсэн тохиолдол нь цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоогүй байх.

2.1.3. “Улбар шар түвшин” (халдвар голомтот тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн тохиолдол болон голомт нь цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоотой, тодорхой хүн амын хүрээнд хязгаарлагдсан байх.

2.1.4. “Улаан түвшин” (халдвар хүн амын дунд өргөн тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногт бүртгэгдсэн тохиолдол нийт хүн амын дунд тархсан байх;

-Шинээр батлагдсан тохиолдлын 25-аас дээш хувьд халдварын эх үүсвэр тодорхойгүй буюу тархвар зүйн холбоогүй байх;

-10000 хүн ам тутамд өвчлөлийн түвшин 5.1-ээс их байх;

-“ПГУ” шинжилгээний эерэг илэрсэн хувь 2.1-ээс их байх;

-10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтийн түвшин 5-аас их байх;

-10000 хүн ам тутамд нас баралтын түвшин 0.1-ээс их байх.

Гурав.Удирдлага, зохион байгуулалт

3.1.Халдварын судалгаа, өвчний мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, тандалтын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн халдварын тархалтын түвшинг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, тухайн шатны эрүүл мэндийн байгууллага тодорхойлж, саналаа Улсын онцгой комисст хүргүүлнэ.

3.2.Энэ журмын 3.1-д заасан байгууллага халдварын тархалтын түвшинг 7 хоног тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүрт тогтоосон аргачлалаар үнэлж, түвшинг өөрчлөх тухай саналаа Улсын онцгой комисст хүргүүлнэ.

3.3.Халдварын тархалтын байдал, эрсдэлийн үнэлгээний дүн, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхаас хамаарч халдварын тархалтын түвшинг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоох, өөрчлөх шийдвэрийг Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу тухайн шатны Онцгой комисс гаргана.

3.4.Засгийн газраас тогтоосон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгтэй уялдуулан улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт халдварын тархалтын түвшинг тогтоох, өөрчлөх шийдвэрийг Улсын онцгой комисс гаргана.

Дөрөв.Халдварын тархалтын түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга биечлэн хариуцаж, зохион байгуулна.

4.2.“Ногоон түвшин”-д төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахгүй, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

4.3.“Шар болон Улбар шар түвшин”-д “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тодорхой хүрээнд хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтооно.